

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо:	2020 оны 08 дугаар сарын 07-ны өдөр
Зээлийн дугаар ба нэр:	Зээл № 3679-МОН: Бүс нутгийн авто замыг хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл
Тендер шалгаруулалтын дугаар:	ЗТХЯ/202005091
Гэрээний дугаар ба нэр:	ДА-1: Дархан-Алтанбулаг чиглэлийн 118 км авто замын аюулгүй байдал, өргөтгөл, шинэчлэлтийн ажил, түүний тоноглол, тэмдэг тэмдэглэгээ
Тендер хүлээн авах огноо ба цаг:	2020 оны 09 дугаар сарын 07-ны өдрийн 15:00 цаг

1. Монгол Улс Азийн Хөгжлийн Банк (цаашид “АХБ” гэх)-наас Бүс нутгийн авто замыг хөгжүүлэх, засвар арчлалтын төслийг хэрэгжүүлэх зорилгоор зээл авсан ба энэхүү санхүүжилтийн тодорхой хэсгийг дээр дурдсан гэрээний хүрээнд хийгдэх төлбөрт ашиглана. Тендер шалгаруулалт нь АХБ-ны эрх бүхий орны харьяат тендер оролцогчдод нээлттэй байна.
2. Монгол Улсын Зам, тээврийн хөгжлийн яам (цаашид “Захиалагч” гэх) эрх бүхий тендер оролцогчдоос ДА-1: Дархан-Алтанбулаг чиглэлийн 118 км авто замын аюулгүй байдал, өргөтгөл, шинэчлэлтийн ажил, түүний тоноглол, тэмдэг тэмдэглэгээ (цаашид “ажил” гэх)-г гүйцэтгэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.
3. Энэхүү тендер шалгаруулалтыг АХБ-ны дотоодын өрсөлдөөнт тендер шалгаруулалтын аргаар явуулна.

Гэрээний дугаар	Байршил	Гүйцэтгэх ажил	Хугацаа
ДА1	ПК226+500- ПК 343+000	118 км авто замын хэсэгчилсэн өргөтгөл болон шинэчлэлтийн ажил	24 сар

4. Зөвхөн доор дурдсан чадварын үндсэн шалгуур үзүүлэлтийг хангасан эрх бүхий тендер оролцогч энэхүү тендер шалгаруулалтад оролцоно. Үүнд:

Шалгуур үзүүлэлт	Багц 1
Барилгын ажлын жилийн дундаж борлуулалт (сүүлийн 3 жилд, 2017, 2018, 2019)	> 6,000,000,000 төгрөг (зургаан тэрбум төгрөг)
Санхүүгийн нөөц хөрөнгө	> 2,500,000,000 төгрөг (хоёр тэрбум таван зуун сая төгрөг)
Барилга угсралтын нэгээс доошгүй гэрээт ажилд оролцсон туршлага	> 6,000,000,000 төгрөг (зургаан тэрбум төгрөг)
Үндсэн үйл ажиллагааны барилгын ажлын туршлага	Хатуу хучилттай авто замын барилгын ажил болон засвар шинэчлэлийн ажил гүйцэтгэж байсан туршлагатай

- Авто зам, замын байгууламжийг барих, засварлах, арчлах дараах тусгай зөвшөөрлүүдтэй байх. Үүнд:

2.8.2.1 Хатуу хучилттай авто зам барих;

2.8.2.5 Бүх төрлийн зам, гүүр, тунель, газар доогуур нүхэн гарам засварлах, замын байгууламжийн арчлалтын ажил

5. Түншлэлийн хэлбэрээр тендерт оролцох эрх бүх оролцогчдын хувьд нээлттэй. Ковид-19-той холбоотойгоор Засгийн газрын шийдвэрийн дагуу орон нутгийн авто замын хөдөлгөөнд хязгаарлалт тавигдаж болохыг анхаарна уу.
6. Сонирхсон тендерт оролцогч тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг дараах хаягаар авч болно.

Тендер хүлээн авах этгээд:

Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн Б.Насантогтох;

Байгууллагын нэр:

Зам, тээврийн хөгжлийн яам

Хаяг:

Чингисийн өргөн чөлөө -11, Засгийн газрын 13 дугаар байр

Давхар ба өрөөний дугаар:

4 давхар, 401 тоот

Хот/дүүрэг:

Улаанбаатар хот

Шуудангийн дугаар:

14251

Имэйл хаяг:

nasantogtokh@mrt.d.gov.mn

Улс:

Монгол Улс

7. Эрх бүхий тендерт оролцогч тендерийн баримт бичгийг худалдан авахыг хүсвэл:

- ДА-1: Дархан-Алтанбулаг чиглэлийн 118 км авто замын аюулгүй байдал, өргөтгөл, шинэчлэлтийн ажил, түүний тоноглол, тэмдэг тэмдэглэгээ тендерийн баримт бичиг авах хүсэлтийг дээрх хаягийн дагуу бичгээр ирүүлнэ.

- Нийт 250,000 /Хоёр зуун тавин мянган /төгрөгтэй тэнцэх буцаан үл олгогдох хураамжийг бэлнээр төлнө.

8. Тендерийг дээр дурдсан хаягаар, тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө тендерийн баримт бичигт шаардсан тендерийн баталгааны хамт ирүүлнэ. Тендерийн баталгаа нь тендер хүчинтэй байх эцсийн хугацаанаас хойш 28 хоногийн хугацаанд хүчинтэй байна. Тендерийг тендер хүлээн авах эцсийн хугацаа дууссан даруйд тендерт оролцогчдын төлөөллийг (хэрэв тэд оролцохыг хүсвэл) байлцуулан нээнэ.